

139



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 129

Номгон

Аймгийн говийн сумдын цахилгаан хангамжийн  
талаар авах зарим арга хэмжээний тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 4/16 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлтийг хэлэлцээд Баянхонгор аймгийн Жинст, Богд, Баянлиг, Баянговь, Баян-Өндөр, Баянцагаан, Шинэжинст сумдын цахилгааны хэвийн ажиллагаа явуулах нөхцөл дутмаг, Өвөрхангай аймгийн төвөөс хамгийн ойр сум 300 км, хамгийн хол сум 500 орчим км зайтай байгаа нь аваарийн болон шуурхай үйлчилгээг үзүүлэх хугацаа урт, сумдын эрчим хүчний ажилчид Өвөрхангай аймаг дахь Эрдэнэт, Булганы цахилгаан түгээх салбарт харьяалагдан ажиллаж тухайн сум орон нутгийн удирдлагатай хамтарч ажилладаггүй, сум орон нутгийн зүгээс цахилгаан хангамжийн шинэчлэл, өргөтгөлийн асуудал дээр хөрөнгө оруулалт хийхэд эзэмшигч байгууллага нь харьяаллын бус, мөн алслагдсан сумууд учир байнгын засвар үйлчилгээ хийж чадахгүй байгаа нь шугам сүлжээг болон дэд станцын ашиглалт муудсан, шинэ хэрэглэгч холболтын зөвшөөрөл авахад Өвөрхангай аймаг руу очдог зэргийг хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Говийн 7 сумын эрчим хүчний шугамын эзэмшигчийг орон нутгийн түгээх компанид шилжүүлэн авч хамтран ажиллах талаар холбогдох байгууллагад уламжлахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай.
2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Э.ЭНХБАТ

